



БАГАНУУР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

БАГАНУУР ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ 2019/9



АГУУЛГА

	Хуудасны дугаар
 ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, 2015-2019 ОН	3
 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙЧҮҮД	4
 НИЙГМИЙН ДААТГАЛ	5
 НИЙГМИЙН ХАЛАМЖ	6
 ЭРҮҮЛ МЭНД	8
 ГЭМТ ХЭРЭГ	9
 ҮНЭ ХАНШ	13
 МАЛ АЖ АХНИ	16
 АЖ ҮЙЛДВЭР	17
 НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	18
 НИЙТИЙН ТЭЭВЭР	19
 ШУУДАН ХОЛБОО	19

ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хүснэгт 1. Малын тоо, 2018 оны жилийн эцэст, малын төрөл, хороогоор

Үзүүлэлт	Дүүргийн дүн	Үүнээс: хороогоор				
		I	II	III	IV	V
Нийт мал	184 337	45 357	11 737	47 457	50 246	29 540
Үүнээс:						
Тэмээ	203	41	-	160	2	-
Адуу	14 652	3 809	701	3 885	3 535	2 722
Үхэр	15 866	4 271	1 388	3 791	3 845	2 571
Хонь	92 757	22 540	5 806	24 208	26 206	13 997
Ямаа	60 859	14 696	3 842	15 413	16 658	10 250

Хүснэгт 2. Хүн ам зүйн үзүүлэлт

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2015 I-IX	2016 I- IX	2017 I- IX	2018 I- IX	2019 I- IX
Суурин хүн ам	тоо	28 419	28 973	28 787	29 512	
Төрөлт	тоо	520	471	451	503	464
Нас баралт	тоо	135	122	106	108	117
Шилжиж ирсэн	тоо	956	753	590	481	311
Цэвэр өсөлт	хувь	1.35	1.20	1.19	1.34	1.18'

' өмнөх оны суурин хүн амаас тооцов.

Зураг 1. Нутаг дэвсгэрийн хэмжээ





БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД


Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны захиргааны статистик мэдээгээр 2019 оны 9 сарын эцэст дүүргийн хөдөлмөрийн албанд бүртгэлтэй, ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэд 299 болж өнгөрсөн оноос 99 (24.9%) хүнээр буурсан байна. Тайлант хугацаанд ажил хайж буй иргэдийн 9 (3.01%) нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд эзэлж байна.

Зураг 2. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн хөдөлгөөн




Тайлант сард ажил идэвхтэй хайж байсан 110 иргэн шинээр бүртгүүлсэн бөгөөд үүнээс 71 (64.5%) нь эмэгтэйчүүд байна.

Зураг 3. Шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэд, шалтгаанаар



Мөн энэ хугацаанд 18 иргэн ажилд зуучлуулан орсон ба үүнээс хязгаарлагдмал хариуцлагатай компанид 13, төрийн бус байгууллагад 1, бусад хэлбэрийн байгууллагад 4 иргэн ажилд орсон байна.

Зураг 4. Бүртгэлтэй ажилгүй иргэд, насны бүлгээр



Тайлант сард ажил идэвхтэй хайж байгаа иргэдийн 54 (18.1%) нь 15-24 насны, 121 (40.5%) нь 25-34 насны залуучууд, 71 (23.7%) нь 35-44 насныхан, 50 (16.7%) нь 45-60 насны, 3 буюу (1.0%) нь 60-аас дээш насны ажилгүй иргэд байна.

Хүснэгт 3. Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролоор, 9 сард

Үзүүлэлт	Ажилгүйчүүдийн тоо		Үүнээс: эмэгтэй	
	2018 IX	2019 IX	2018 IX	2019 IX
Ажилгүйчүүд, бүгд	389	299	215	176
Үүнээс:				
Дээд боловсролтой	104	81	80	53
Тусгай дунд боловсролтой	23	20	10	12
Мэргэжлийн анхан шатны боловсролтой	35	44	10	23
Ерөнхий боловсролтой	220	143	112	82
Бага болон боловсролгүй	7	11	3	6

Ажил идэвхтэй хайж буй иргэдийн 81 (27.1%) нь дээд боловсролтой, 20 (6.7%) нь тусгай дунд боловсролтой, 44 (14.7%) нь мэргэжлийн анхан шатны боловсролтой, 143 (47.8%) нь ерөнхий боловсролтой, 11 (3.7%) нь бага боловсролтой болон боловсролгүй ажээ. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 176 (58.8%) нь эмэгтэйчүүд байна.




НИЙГМИЙН ДААТГАЛ

Тайлант хугацаанд нийгмийн даатгалын сангийн орлого 12.2 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 440.9 (3.7%) сая төгрөгөөр, зарлага 17.3 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 1.5 (9.6%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Нийт орлогын 7.6 (62.0%) тэрбум төгрөг тэтгэврийн сангаас, 966.7 (7.9%) сая төгрөг тэтгэмжийн сангаас, 1.3 (10.3%) тэрбум төгрөг ҮОМШӨ сангаас, 2.2 (18.1%) тэрбум төгрөг эрүүл мэндийн даатгалын сангаас, 204.1 (1.7%) сая төгрөг ажилгүйдлийн сангаас тус тус төвлөрсөн байна.

Зураг 5. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, сараар




Хүснэгт 4. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага

Үзүүлэлт	2018		2019		2019.IX% 2018.IX	2019.I – IX% 2018.I – IX
	IX	I-IX	IX	I-IX		
	сая төгрөг					
Сангийн орлого, бүгд	1 401.5	11 773.5	1 816.7	12 214.4	129.6	103.7
тэтгэврийн сан	867.1	7 260.1	1 124.7	7 571.1	129.7	104.3
тэтгэмжийн сан	111.8	932.0	144.8	966.7	129.5	103.7
ажилгүйдлийн сан	23.8	198.1	31.0	204.1	130.3	103.0
ҮОМШӨ ¹ -ний сан	144.3	1 214.3	188.9	1 257.7	130.9	103.6
ЭМД ² -ын сан	254.5	2169.0	327.3	2 214.8	128.6	102.1
Сангийн зарлага, бүгд	1 758.8	15 767.1	1 941.1	17 281.8	110.4	109.6
тэтгэврийн сан	1 511.0	13 360.0	1 695.1	14 991.1	112.2	112.2
тэтгэмжийн сан	96.0	835.0	67.5	739.6	70.3	88.6
ҮОМШӨ-ний сан	127.8	1 362.1	147.7	1 308.9	115.6	96.1
ЭМД-ын сан	-	-	-	-	-	-
Ажилгүйдлийн сан	24.0	210.0	30.8	242.2	128.3	115.3

¹ Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

² Эрүүл мэндийн даатгал

Зураг 6. Нийгмийн даатгалын сангийн зарлагын бүтэц



Тайлант хугацаанд нийгмийн даатгалын сангаас 4245 хүнд 15.0 тэрбум төгрөгийн тэтгэвэр, 2530 хүнд 739.6 сая төгрөгийн тэтгэмж, 581 хүнд 1.3 тэрбум төгрөгийн үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэмж, 118 хүнд 242.2 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж тус тус олгосон байна.




НИЙГМИЙН ХАЛАМЖ

2019 оны эхний 9 сарын байдлаар нийгмийн халамжийн сангийн орлого 3.0 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 338.2 (12.7%) сая төгрөгөөр өссөн байна. Нийгмийн халамжийн сангийн нийт орлогын 2.9 (97.0%) тэрбум төгрөг улсын төсвөөс, 81.5 (2.7%) сая төгрөг орон нутгийн төсвөөс 9.0 (0.3%) сая төгрөг бусад орлогоор тус тус санхүүжигдсэн байна.

Тайлант хугацаанд нийгмийн халамжийн сангаас 482 хүнд 675.2 сая төгрөгийн тэтгэвэр, 330 хүнд 217.7 сая төгрөгийн тэтгэмж, 235 жирэмсэн эхчүүдэд 80.3 сая төгрөгийн тэтгэмж, “Алдарт эх”-ийн одонтой 2765 эхчүүдэд 276.5 сая төгрөг, 1699 эх “Цалинтай ээж” хөтөлбөрт хамрагдаж 531.8 сая төгрөг, 1348 ахмадуудад 226.1 сая төгрөгийн насны хишиг олгосон байна.

Ахмад дайчин, гавьяат цолтой 21 хүнд 25.1 сая төгрөг, 329 ахмад настанд 236.0 сая төгрөгийн хөнгөлөлт үзүүлж, 3076 хүнийг хүнс тэжээлийн хөтөлбөрт хамруулж 338.7 сая төгрөг, 322 хүнд амжиргаа дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж 139.7 сая төгрөг, 46 өрх толгойлсон эцэг эхэд 45.8 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй 46 иргэдэд 39.1 сая төгрөгийн хөнгөлөлт тус тус олгосон байна.

Зураг 7. Нийгмийн халамжийн сангийн зарлагын бүтэц



Хүснэгт 5. Нийгмийн халамжийн сангийн орлого, зардал

Үзүүлэлт	2018		2019		2019.IX% 2018.IX	2019.I – IX% 2018.I – IX
	IX	I-IX	IX	I-IX		
	Сая төгрөг					
Сангийн орлого	149.7	2 657.2	273.3	2 995.4	182.6	112.7
Улсын төсвөөс	149.5	2 607.5	270.0	2 904.9	180.6	111.4
Орон нутгийн төсвөөс	-	44.4	2.4	81.5	-	183.6
Бусад орлого	0.2	5.3	0.9	9.0	450.0	169.8
Сангийн зарлага	163.8	2 631.8	321.0	2 864.3	196.0	108.8
Тэтгэвэр	66.6	620.6	80.7	675.2	121.2	108.8
Тэтгэмж	29.7	329.1	29.6	217.7	99.7	66.2
Амжиргаа дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж	-	-	16.3	139.7	-	-
"Алдарт эх" I одонт эхчүүд	-	134.6	-	129.1	-	95.9
"Алдарт эх" II одонт эхчүүд	-	142.0	0.8	147.4	-	103.8
Жирэмсэн эхчүүдийн тэтгэмж	9.3	99.0	11.0	80.3	118.3	81.1
Насны хишиг	-	215.1	1.1	226.1	-	105.1
Ахмад дайчин, гавьяатын нэмэгдэл	-	20.6	3.7	25.1	-	121.8
Ахмад настанд үзүүлсэн хөнгөлөлт	16.0	210.1	47.8	235.9	298.8	112.3
ХБИ-д үзүүлсэн хөнгөлөлт	4.2	35.7	8.7	39.1	207.1	109.5
"Хүнс тэжээл" халамжийн хөтөлбөр	34.5	293.7	45.0	338.7	130.4	115.3
Цалинтай ээж	-	480.6	60.3	531.8	-	110.7
Өрх толгойлсон эцэг, эхийн тэтгэмж	-	22.1	15.1	45.8	-	207.2


ОНО-д түшиглэсэн халамж	3.2	22.0	0.7	28.0	21.9	127.3
Бусад үйлчилгээ	0.3	6.6	0.2	4.4	66.7	66.7



ЭРҮҮЛ МЭНД

Дүүргийн хэмжээнд 2019 оны эхний 9 сард 477 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс 46 (8.8%) хүүхдээр буурсан байна. Энэ хугацаанд 171355 хүн үзлэгт хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 8667 (5.3%) хүнээр өссөн бол хэвтэн эмчлүүлсэн 6175 хүн байгаа нь өмнөх оны мөн үеэс 108 (1.7%) хүнээр буурсан байна.


Зураг 8. Амбулаторийн үзлэг 2019 оны I-IX сар



Хүснэгт 6. Төрсөн хүүхэд, эх, хүүхдийн эндэгдэл эхний 9 сард

Үзүүлэлт	2018 I-IX	2019 I-IX	$\frac{2019.IX\%}{2018.IX}$
Амаржсан эхийн тоо	523	477	91.2
Үүнээс бусад аймгийн харьяат	131	127	96.9
Амьд төрсөн хүүхэд	527	477	90.5
Үүнээс бусад аймгийн харьяат	134	127	94.8
Эхийн эндэгдэл	-	-	-
Нэг хүртэлх насандаа эндсэн хүүхэд	2	2	100.0

Зураг 9. Халдварт өвчин, сараар



2019 оны эхний 9 сард халдварт паразит өвчний 134 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 46.7%-ийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 36 (21.2%) тохиолдлоор, цочмог халдварт өвчний 153 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 53.3%-ийг

эзэлж, өмнөх оны мөн үеэс 116 (43.1%) тохиолдлоор тус тус буурсан байна. Дүүргийн дунджаар 10000 хүн тутамд ногдох халдварт өвчнөөр өвчлөгсдийн тоо 97.2 байгаа нь өмнөх оны мөн үеэс 54.8 продициллээр буурсан байна.

Хүснэгт 7. Бүртгэгдсэн халдварт өвчин

Үзүүлэлт	2018 I-IX	2019 I-IX	Өсөлт бууралт
Халдварт, паразит өвчин	170	134	-36
Заг хүйтэн	65	56	-9
Тэмбүү	57	36	-21
Мөөгөнцөр /кандидоз/	14	5	-9
Трихомониаз	28	33	5
Кандилом	2	3	1
Хомхой	4	1	-3
Цочмог халдварт өвчин	269	153	-116
Цусан суулга	41	39	-2
Гепатит А	7	3	-4
Скарлатин	3	5	2
Хоолны хордлого	58	-	-58
Салхин цэцэг	85	79	-6
Сальмонеллез	2	-	-2
Рож	2	-	-2
Гар хөл амны өвчин	55	9	-46
Сүрьеэ	16	18	2
Нийт халдварт өвчин	439	287	-152



ГЭМТ ХЭРЭГ


2019 оны эхний 9 сард дүүргийн хэмжээнд 141 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 55 (28.1%) хэргээр буурсан байна. Гэмт хэргийн илрүүлэлт 55.0 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 5.3 пунктээр дээгүүр үзүүлэлт юм.

Хүснэгт 8. Бүртгэгдсэн гэмт хэрэг

Хэргийн төрөл	2018 I-IX	2019 I-IX	Хэргийн өсөлт		Дүнд эзлэх хувь
			тоо	хувь	
Бүртгэгдсэн гэмт хэрэг, бүгд	196	141	-55	-28.1	100
Хүний амь нас хохирсон	3	5	2	66.7	3.5
Хүний амь нас хохироосон	-	2	2	-	1.4
Хүний эрүүл мэндэд хохирол учруулах	78	43	-35	-44.9	30.5
Гэр бүлийн хүчирхийлэл	3	-	-3	-100.0	0.0
Бэлгийн халдашгүй байдал	8	4	-4	-50.0	2.8
Эмнэлгийн тусламж үзүүлэхгүй байх	-	1	1	-	0.7
Хүүхдэд садар самуун сурталчилах уруу татах	-	2	2	-	1.4

Бусдын эд хөрөнгө хулгайлах	54	30	-24	-44.4	21.3
Бусдын эд хөрөнгө дээрэмдэх	-	1	1	-	0.7
Гээгдэл эд зүйл завших, алдаатай гүйлгээ хийх	9	8	-1	-11.1	5.7
Залилан мэхлэх	8	21	13	162.5	14.9
Хөрөнгө завших	1	4	3	300.0	2.8
Авто тээврийн хэрэгсэл хууль бусаар авч явах	-	1	1	-	0.7
Мал хулгайлах	8	6	-2	-25.0	4.3
Тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчих	8	9	1	12.5	6.4
Болгоомжгүйгээр эд хөрөнгө устгах гэмтээх	1	-	-1	-100.0	0.0
Эд хөрөнгө устгах гэмтээх	4	1	-3	-75.0	0.7
Хууль сахиулагчийг эсэргүүцэх	7	1	-6	-85.7	0.7
Цахим мэдээлэлд хууль бусаар халдах	-	1	1	-	0.7
Орчиндоо аюул учруулах амьтан зохих хамгаалалтгүй орхисон	1	-	-1	-100.0	0.0
Мансууруулах сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэх	1	1	-	0.0	0.7
Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны	1	-	-1	-100.0	0.0
Галт зэвсэг тэсэрч дэлбэрэх бодис хууль бусаар эзэмших	1	-	-1	-100.0	0.0
Хэрэг илрүүлэлтийн хувь	49.7	55.0			


Зураг 10. Бүртгэгдсэн гэмт хэрэг, сараар



Бүртгэгдсэн гэмт хэргийн дийлэнх буюу 43 (22.1%) нь хүний эрүүл мэндэд хохирол учруулах хэрэг, 30 (15.4%) нь бусдын эд хөрөнгө хулгайлах, 21 (10.8%) нь залилан мэхлэх хэрэгүүд байна.

Тайлант хугацаанд хүний эрүүл мэндэд хохирол учруулах гэмт хэрэг 40, бусдын эд хөрөнгө хулгайлах хэрэг 30, залилан мэхлэх хэрэг 21, тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчих хэрэг 9, гээгдэл эд зүйл завших, алдаатай гүйлгээ хийх хэрэг 8, мал хулгайлах гэмт хэрэг 6, хүний амь нас хохирсон хэрэг 5, бэлгийн халдашгүй байдлын гэмт хэрэг, хөрөнгө завших гэмт хэрэг тус бүр 4, хүний амь нас хохироосон, хүүхдэд садар самуун сурталчилах уруу татах, хэрэг тус бүр 2, эмнэлгийн тусламж үзүүлэхгүй байх, бусдын эд хөрөнгө дээрэмдэх, цахим мэдээлэлд хууль бусаар халдах, эд хөрөнгө устгах, мансууруулах сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэх, хууль сахиулагчийг эсэргүүцэх, авто тээврийн хэрэгсэл хууль бусаар авч явах хэрэгүүд тус бүр 1 бүртгэгдсэн байна.

Зураг 11. Согтуугаар болон гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг, сараар



Зураг 12. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг, жил бүрийн эхний I-IX сард




Хүснэгт 9. Гудамж талбайд болон согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг

Хэргийн төрөл	2018 I-IX		2019 I-IX	
	Согтуугаар	Гудамж талбайд	Согтуугаар	Гудамж талбайд
Бүгд	76	30	42	16
Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	1			
Хүний амь нас хохироосон			1	1
Хүний эрүүл мэндэд хохирол учруулах	60	13	34	5
Бэлгийн халдашгүй байдал	2			
Бусдын эд хөрөнгө хулгайлах	3	8	4	8
Бусдын эд хөрөнгө дээрэмдэх			1	
Хөрөнгө завших		1		
Авто тээврийн хэрэгсэл хууль бусаар авч явах				1
Болгоомжгүйгээр эд хөрөнгө устгах гэмтээх	1	1		
Гээгдэл эд зүйл завших, алдаатай гүйлгээ хийх		1		1
Тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчих	2		1	
Эд хөрөнгө устгах гэмтээх	1	2	1	
Хууль сахиулагчийг эсэргүүцэх	6	4		
Дүнд эзлэх хувь	38.8	15.3	29.8	11.3

Тайлант хугацаанд согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 42 болж өмнөх оны мөн үеэс 34 (44.7%) хэргээр, гудамж талбайд 16 хэрэг үйлдэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 14 (46.7%) хэргээр тус тус буурсан байна. Мөн согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг нийт гэмт хэргийн 29.8 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 9.0 пунктээр, гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг нийт хэргийн 11.3 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 4.0 пунктээр тус тус буурсан байна.


Зураг 13. Гудамж талбайд болон согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн эзлэх хувь, жил бүрийн I-IX сар



Хүснэгт 10. Гэмт хэрэгт холбогдсон хүмүүс

Үзүүлэлт	Хүний тоо		Өсөлт, бууралт	
	2018 I-IX	2019 I-IX	тоо	хувь
Гэмт хэрэгт холбогдсон хүн	126	92	-34	-27.0
Үүнээс: эмэгтэйчүүд	10	13	3	30.0
хүүхэд	11	8	-3	-27.3
Гэмт хэргийн улмаас хохирсон хүн	200	143	-57	-28.5
Үүнээс: нас барсан	5	12	7	140.0
гэмтсэн	79	52	-27	-34.2
Саатуулагдсан хүний тоо	996	633	-363	-36.4
Баривчлагдсан хүний тоо	107	130	23	21.5
Учирсан хохирол /сая төгрөг/	226.5	231.6	5.1	2.3
Нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ /сая төгрөг/	46.6	142.1	95.5	204.9

Зураг 14. Гэмт хэрэгт холбогдсон иргэд, хувиар, 2019 I-IX сар



Тайлант хугацаанд гэмт хэрэгт 92 иргэн холбогдон шалгагдсан нь өмнөх оноос 34 (27.0%) хүнээр буурсан байна. Гэмт хэрэгт холбогдсон иргэдийн 13 (14.1%) нь эмэгтэйчүүд, 8 (8.7%) нь хүүхэд байна.

Эхний 9 сарын байдлаар гэмт хэргийн улмаас 52 хүн гэмтэж, 12 хүн нас барсан байна. Тайлант хугацаанд 633 хүн саатуулагдсан нь өнгөрсөн оны мөн үеэс 363 (36.4) хүнээр буурсан байна. Гэмт хэргийн улмаас 231.6 сая төгрөгийн хохирол учирсны 142.1 (61.4) сая төгрөгийг нөхөн төлүүлжээ.



ҮНЭ ХАНШ

2019 оны 9 сарын хүнсний өргөн хэрэглээний 21 нэр төрлийн бүтээгдэхүүний дундаж үнийг ажиглахад доорх байдалтай байна.

Хүснэгт 11. Хүнсний барааны үнийн ажиглалт, 2019 оны 9 сарын дундаж үнэ

Хүнсний бараа		Хэмжих жлгөн	Хишиг-Уул супер маркет	Марал хүнсний дэлгүүр	Хэрлэн хүнсний зах	Миний нутаг супер маркет
"Алтан тариа" гурил	Дээд	кг	1 425	1 500		1 500
	I зэрэг	кг	1 100	1 200		1 200
	II зэрэг	кг	900	950		900
Будаа	цагаан	кг	2 500	2 400		2 400
	шар	кг	1 450	1 500		1 600
Хонины мах	ястай	кг			8 125	
	цул	кг			9 625	
Үхрийн мах	ястай	кг			8 875	
	цул	кг			11 000	
Адууны мах, ястай		кг			8 125	
Ямааны мах		кг			8 125	
Элсэн чихэр		кг	2 200	2 200		2 100
Сүү /задгай/		л	1 000			
Тараг /задгай/		л	1 425			
Цэцгийн тос, Орос		кг	4 000	4 000		4 000
Байцаа		кг			1 350	
Манжин		кг			1 350	
Төмс	монгол	кг			625	
Лууван	монгол	кг			1 350	
Сонгино	хятад	кг			1 500	
	монгол	кг			12 500	
Сармис, булцуу		ш			300	
Огурцы, хятад		кг			4 500	
Помидор, хятад /үрлэн/		кг			4 500	
Ургамлын тос/ sunny gold/		ш	4 200	4 125		4 200


Өндөг		ш	400	350		350
Талх	Есөн шанд	том 900 гр	ш	1 800	1 800	1 800
		Дунд 700 гр	ш	1 700	1 700	1 700
		жижиг 500 гр	ш	1 100	1 100	1 100
	Атар талх	ш	1 150	1 200	1 200	

Хүснэгт 12. Үйлчилгээний үнийн тариф, (НӨТ-гүй үнэ)


Үзүүлэлт	Хэмжин нэгж	Айл өрхөд (төгрөг)	Хэмжин нэгж	Аж ахуйн нэгж байгууллагад (төгрөг)	
Дулаан	1м ²	660	1м ³	1632	
Дулааны суурь тариф	40 м ² хүртэл	3 000			
	40м ² - 80м ²	5 000	-	-	
	81м ² -аас дээш	10 000			
Халуун ус	Өвөл	1 хүн (тоолуургүй)			
		1м ³ (тоолууртай)	1 632		
	Зун	1 хүн (тоолуургүй)	4 428	1 ккал	76 611
		1м ³ (тоолууртай)	1 632		
Цэвэр ус*	1 хүн (тоолуургүй)	0.8	1 л (тоолуургүй)	1.50	
	1 л (тоолууртай)	0.65	1 л (тоолууртай)	1.20	
	суурь хураамж	1 800	1 л (зөөврөөр)	5.45	
Бохир ус*	1 хүн (тоолуургүй)	0.99	1 л (тоолуургүй)	1.8	
	1 л (тоолууртай)	0.73	1 л (тоолууртай)	1.4	

* 2019 оны 9 сарын 15-нээс мөрдөж байгаа тариф

Зураг 15. “Алтан тариа” гурилын дундаж үнэ, жил бүрийн 9-р сард



Зураг 16. Нэг кг махны дундаж үнэ, жилийн бүрийн 9-р сард



Хүснэгт 13. Цахилгааны үнийн тариф, (НӨТ-гүй үнэ)

Хэрэглэгчдийн ангилал	Хэмжих нэгж	Тариф (НӨАТ-гүй)
* Айл өрхөд борлуулах цахилгааны тариф		
Энгийн тоолууртай		
Сарын нийт хэрэглээний 150 кВт.ц	төг/квт.ц	102.9
Сарын нийт хэрэглээний 151 кВт.ц-аас дээш	төг/квт.ц	122.7
2 тарифт тоолууртай		
Өдрийн хэрэглээ /06.00-21.00/	төг/квт.ц	108.8
Орой, шөнийн хэрэглээ /21.00-06.00/	төг/квт.ц	81.6
Сарын суурь тариф	төг/сар	2 000.0
* Аж ахуйн нэгж, байгууллагад борлуулах цахилгааны тариф		
Энгийн тоолууртай /бусад үйлдвэр аж ахуйн нэгж байгууллага/		
Өдрийн хэрэглээ /06.00-17.00/	төг/квт.ц	133.0
Оройн хэрэглээ /17.00-24.00/	төг/квт.ц	214.3
Шөнийн хэрэглээ /24.00-06.00/	төг/квт.ц	81.6
3 тарифт тоолууртай /уул уурхай, боловсруулах аж үйлдвэр/		
Өдрийн хэрэглээ /06.00-17.00/	төг/квт.ц	155.9
Оройн хэрэглээ /17.00-24.00/	төг/квт.ц	276.0
Шөнийн хэрэглээ /24.00-06.00/	төг/квт.ц	77.1

* 2019 оны 5 сарын 1-ны өдрөөс мөрдөж буй тариф

Хүснэгт 14. Малын гаралтай бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ


	2017 IX	2018 IX	2019 IX
	төгрөг		
Адууны шир	20 000	10 000	7 500
Үхрийн шир /2.3 метрээс доош/	15 000	8 000	3 000
Үхрийн шир /2.3 метрээс дээш/	20 000	13 000	10 000
Хонины арьс	3 000	2 000	2 000
Ямааны арьс	7 000	5 000	1 000

Хүснэгт 15. Түлш шатахууны үнэ

Шатахууны нэр төрөл	2015 IX	2016 IX	2017 IX	2018 IX	2019 IX	Өөрчлөлт	
						төгрөг	хувь
АИ -76,80	1 560	1 140	1 480	1 648	1 810	162	9.8
АИ -92,93	1 700	1 540	1 630	1 840	1 860	20	1.1
Дизель түлш	1 830	1 650	1 720	2 170	2 390	220	10.1

2019 оны 9 сарын байдлаар түлш, шатахууны үнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад АИ-80 бензин 162 төгрөгөөр (9.8), АИ-92 бензин 20 төгрөгөөр (1.1), дизель түлш 220 төгрөгөөр (10.1) тус тус өссөн байна.

Зураг 17. Хот хоорондын зорчигч тээврийн үнэ, (чиглэл: УБ-БН, БН-УБ)



МАЛАЖ АХУЙ

2019 оны эхний 9 сард 66522 эх мал төллөж 66527 төл гарснаас 754 толгой төл мал хорогдсон байна. Энэ нь нийт гарсан төлийн 1.1 хувийг эзэлж байна. Одоогоор 65773 төл мал бойжиж байгаа ба төл бойжилт 98.9%-тай байна. Мал тооллогын дүнгээр энэ онд 84465 толгой эх мал төллөхөөс 66522 эх мал төллөсөн байгаа нь 78.8%-тай байна.

Хүснэгт 16. Том малын зүй бус хорогдол

	Нийт хорогдол	Үүнээс:				
		Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
ДҮН	1 248	-	108	75	550	515
1 хороо	299	-	25	35	99	140
2 хороо	24	-	1	3	10	10
3 хороо	409	-	57	19	198	135
4 хороо	244	-	11	13	92	128
5 хороо	272	-	14	5	151	102

Тайлант хугацаанд зүй бусаар хорогдсон 1248 толгой том мал байгаагаас 330 толгой нь хээлтэгч мал байна. Нийт хорогдсон мал нь өнгөрсөн онд тоологдсон нийт малын 0.7 хувийг эзэлж байна. Нийт хорогдсон том малаас өвчнөөр хорогдсон 26 толгой мал байна.



АЖ ҮЙЛДВЭР


Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэлт 2019 оны эхний 9 сард 96.2 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 2275.2 (2.4%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 17. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт


Үзүүлэлт	Хэмжих нэгж	Биет хэмжээ			Үнийн дүн, сая төгрөг		
		2018 I-IX	2019 I-IX	2019/2018 %	2018 I-IX	2019 I-IX	2019/2018 %
Нүүрс олборлолт	м.тн	2 780.5	2 790.3	9.8	85 652.6	89 029.6	3 377.0
Дулаан дамжуулалт	м.гкал	103.6	96.5	-7.1	3 190.4	3 109.3	-81.1
Талх үйлдвэрлэлт	тн	122.4	142.8	20.4	169.4	197.2	27.8
Нарийн боов үйлдвэрлэлт	тн	53.9	49.9	-4.0	209.9	244.2	34.3
Арматур үйлдвэрлэл	тн	3 200.0	2 231.3	-968.7	4 652.8	3 570.0	-1 082.8
Нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт		6 260.4	5 310.8	-949.6	93 875.1	96 150.3	2 275.2

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн биет хэмжээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад нүүрс олборлолт 9.8 (0.35%) мянган тонноор, талх үйлдвэрлэлт 20.4 (16.7%) тонноор өссөн байна. Харин дулаан дамжуулалт 7.1 (6.9%) мянган гкалаар, арматур үйлдвэрлэлт 968.7 (30.3%) тонноор, нарийн боов үйлдвэрлэлт 4.0 (7.4%) тонноор тус тус буурсан байна.


Зураг 18. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, сая төгрөг, сараар



Зураг 19. Талх, нарийн боов үйлдвэрлэлт, сараар, мянган төгрөг



Зураг 20. Нүүрс олборлолт, мянган тонн, жил бүрийн I-IX сард



Харин аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг үнийн дүнгээр өмнөх оны мөн үетэй харьцуулахад нүүрс олборлолт 3377.0 (3.9%) сая төгрөгөөр, талх үйлдвэрлэлт 27.8 (16.4%) сая төгрөгөөр, нарийн боов үйлдвэрлэлт 34.3 (16.3%) сая төгрөгөөр тус тус өссөн бол, дулаан дамжуулалт 81.1 (2.5%) сая төгрөгөөр, арматур үйлдвэрлэлт 1082.8 (23.3%) сая төгрөгөөр тус тус буурсан байна.




НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Тайлант хугацаанд нийтийн аж ахуй үйлчилгээний салбарын орлого 1403.5 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 127.2 (10.0%) сая төгрөгөөр өссөн байна. Нийт орлогын 677.2 (48.3%) сая төгрөгийг хүн амаас оруулсан орлого эзэлж байна.

Хүснэгт 18. Орон сууц нийтийн аж ахуйн орлого

Үзүүлэлт	2018 I-IX	2019 I-IX	Өсөлт бууралт
	сая төгрөг		
Нийт орлого	1 276.3	1 403.5	127.2
Орон сууц	187.6	241.7	54.1
Ус борлуулалт, бүгд	562.1	582.2	20.1
Хүн амд	234.6	288.1	53.5
Аж ахуйн нэгжид	326.0	294.1	-31.9
Үйлчилгээний байгууллагад	1.5	-	-1.5
Сувагжуулалт	450.5	494.3	43.8
Бусад	76.1	85.3	9.2

Зураг 21. Нийтийн үйлчилгээний салбарын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл, сая төгрөг



Хүснэгт 19. Сууц өмчлөгчдийн холбоодын орлогын биелэлт

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	ТБ%
	сая төгрөг		
Нийт дүн	382.3	303.2	79.3
Тавлаг өргөө	72.3	57.9	80.1
Маргад өргөө	74.8	59.3	79.3
Сод хөгжил	85.2	76.2	89.4
Шинэ элч	80.4	61.1	76.0
Уурхайчин	32.5	23.7	73.0
Содон суварга	37.1	24.9	67.2



НИЙТИЙН ТЭЭВЭР

2019 оны эхний 3 улиралд нийтийн тээврийн салбар 8643.0 мянган хүн километрийн ажил үйлчилгээг гүйцэтгэн, давхардсан тоогоор нийтдээ 169.2 мянган хүн тээвэрлэж, 625.9 сая төгрөгийн орлоготой ажилласан байна.

Хүснэгт 20. Тээврийн салбарын үзүүлэлт

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2018 I-IX	2019 I-IX	Өсөлт бүүралт
Нийт орлого	сая.төгрөг	790.7	625.9	-164.8
Тээсэн зорчигч	мян.хүн	246.5	169.2	-77.3
Зорчигч эргэлт	мян.хүн.км	13 127.3	8 643	-4 484.3

Өмнөх оны мөн үеэс зорчигчдын тоо 77.3 (31.4%), мянган хүнээр, үйлчилгээний орлого 164.8 (20.8%) сая төгрөгөөр тус тус буурсан байна.




ШУУДАН ХОЛБОО

Шуудан холбоо, үйлчилгээний орлого 2019 оны эхний 3 улиралд 304.2 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 112.7 (58.9%) сая төгрөгөөр, хүн амаас орсон орлого 130.1 сая төгрөг болж 28.0 (27.4%) сая төгрөгөөр тус тус өссөн байна. Нийт орлогын 42.8 хувийг хүн амаас орсон орлого эзэлж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.5 пунктээр буурсан байна.

Хүснэгт 21. Шуудан холбооны үзүүлэлтүүд

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2018 I-IX	2019 I-IX	Өсөлт бууралт
Холбооны үйлчилгээний орлого	сая төг	191.5	304.2	112.7
Үүнээс: хүн амаас орсон орлого	сая төг	102.1	130.1	28.0
Суурин телефон цэг	тоо	668	647	-21
Үүнээс айл өрхийн	тоо	257	259	2

Зураг 22. Суурин телефон цэгийн тоо, жил бүрийн I-IX сард



Тайлант хугацаанд суурин телефон цэгийн тоо 647 болж өмнөх оны мөн үеэс 21 (3.1%) цэгээр буурсан байна. Шуудангийн үйлчилгээний салбар эхний 9 сард 9.1 мянган ширхэг бичиг захидал, 0.8 мянган ширхэг илгээмж, 108.0 мянган ширхэг тогтмол хэвлэлийг хэрэглэгчдэд хүргэсэн байна.

БАГАНУУР ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

2019 оны 9 дүгээр сарын 16 өдөр

WWW.1212.MN СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН

Статистик 

Мэдээ, мэдээлэл 

Номын сан 

Мэдлэгээ шалгах
ТОГЛОМ 

Валютын ханш 



аппликейнаас

СТАТИСТИКИЙН мэдээллээ аваарай

Data lab

тооллого судалгааны
микро мэдээллийн сан



Social network



www.facebook.com/StatisticMongolia/



www.twitter.com/statistic_mn

Лавлах утас



1900-1212

Цахим шуудан



information@nso.mn